

АСЕМ БА МОНГОЛ УЛС

Д.Уламбаяр¹

Keywords: *new asian strategy, enhanced partnership, European Commission, secretariat of ASEAN, Asia-Europe meeting, strategic framework, political dialogue, observer status, multilateral cooperation, economic diplomacy, trans-continental integration, asianisation, Asian Monetary Fund, climate change, KEDO, intercivilisation dialogue, international terrorism, etc.,*

Abstracts: *This article talks about a key issues of trans-continental integration, such is EU and ASEAN, their cooperation and partnership, challenges and opportunities*

Зохиогч профессор Д.Уламбаяр миний бие АСЕМ-ын түүх, АСЕМ ба Монгол Улсын харилцааны дурдсан асуудлыг бүр арван жилийн өмнө 2006 онд хэвлүүлсэн «Монгол Улс Улс, Өрнө дахин: харилцаа, хамтын ажиллагаа. XX зууны эхнээс XXI зууны эхэн»² [410 тал] бүтээлдээ анх удаа дэлгэрэнгүй хөндөн тавьсан билээ.

2016 оны 7 дугаар сард АСЕМ-XI саммит Улаанбаатар хотноо анх удаагаа зохион байгуулагдах гэж байна. Энэ жил АСЕМ-ын түүхэн хөгжилийн 20 жилийн ой тохиож байгаа юм. 2014 оны 10 дугаар сард Италийн Милан хотноо зохион байгуулагдсан АСЕМ-X саммит дараагийн зохион байгуулах эрхийг Улаанбаатарт шилжүүлсэн юм.

1994 оны 7 дугаар сард Европын Холбоо (ЕХ) ХБНГУ-ын санаачилгаар *Шинэ Азийн Стратеги өөд (Towards a New Asian Strategy)* баримт бичгээ баталсаны дараа Ази-Европын дээд уулзалт хийх санаачилгыг анх 1994 оны 10 дугаар сард Сингапурын Ерөнхий сайд Го Чок Тонг (Goh Chok Tong) Францад айлчилах үеэрээ гаргажээ. (1)

1. Д.Уламбаяр. ХИС-ийн Олон улсын харилцаа, нийгэм судлалын сургуулийн захирал, *Доктор, профессор*
2. Д.Уламбаяр. Монгол Улс, Өрнө дахин: Харилцаа, хамтын ажиллагаа. XX зууны эхнээс XXI зууны эхэн. УБ. 2007, 292-309 дэх тал

Улмаар мөн оны 11 дүгээр сард АСЕАН-ЕХ-ны Гадаад хэргийн сайд нарын анхны уулзалтаар АСЕМ-ын үндэс суурийг тавьжээ.

АСЕМ (Asia-Europe meetings: ASEM) нь Ази, Европын орнуудын хамтын ажиллагааг харилцан хүндэтгэх, эрх тэгш хамтран ажиллах зарчмын үндсэн дээр өргөжүүлэн хөгжүүлэх зорилготой үйл явц бөгөөд одоогийн байдлаар АСЕАН-ы 10 орон Бруней, Вьетнам, Лаос, Камбож, Индонези, Малайз, Мьянмар Сингапур, Тайланд, Филиппин болон БНСУ, БНХАУ, Япон, ЕХ-ны 28 орон (Хорват 2013 оны 7 дугаар сарын 1-нээс ЕХ-нд элссэн), шинэ гишүүд болох Монгол, Энэтхэг, Пакистан (2008), Австрали, ОХУ, Шинэ Зеланд, (2010), Бангладеш, Норвеги, Швейцари (2012), Казахстан (2014 оны 10 дугаар сард Италийн Милан хотноо зохиогдсон АСЕМ-Х дээд уулзалтаар элссэн), АСЕАН-ны нарийн бичгийн дарга нарын газар, Европын Комиссыг хамарч байна.

АСЕМ-ын үйл ажиллагаа дараах механизмаар явагдаж байгаа юм. Үүнд: Хоёр жил тутам хоёр тивд ээлжлэн болдог төр, засгийн тэргүүн нарын дээд уулзалт АСЕМ-ын үйл ажиллагааны гол чиглэлүүдийг тодорхойлж байна. Дээд уулзалтуудын хооронд жил тутам болдог Гадаад хэргийн сайд нарын хуралдаанд улс төрийн асуудлаар яриа хэлэлцээр өрнүүлж АСЕМ-ын үйл ажиллагааг бүхэлд нь зохицуулах үүрэгтэй ажээ.

Тэрчлэн Эдийн засгийн болон Сангийн, мөн Байгаль орчны сайд нарын хуралдаан 1997, 1999, 2001, 2003, 2005, 2006, 2007, 2008, 2009, 2010, 2011, 2012, 2013, 2014, 2015 онуудад болж холбогдох салбарын хамтын ажиллагааны асуудлыг хэлэлцэж ирсэн байна. Харин худалдаа, хөрөнгө оруулалт хариуцсан ахлах тушаалтнуудын зөвлөлгөөнөөр дээд уулзалт, сайд нарын хуралдааны бэлтгэл хангах, ДХБ-ын шаардлагад үйл ажиллагаагаа нийцүүлэх, түншүүдээс дэвшүүлж байгаа хамтын ажиллагааны шинэ саналуудад сонголт хийж, АСЕМ-ийн үйл ажиллагааг зохицуулдаг. Дөрвөн гол зохицуулагчдад ЕХ-г даргалж буй орон, Европын Комисс, Азийн хэсгээс ЗӨА, ЗХА-иас тус бүр нэг орон ордог.

2001 оны 5 дугаар сард Бээжин хотноо болсон АСЕМ-ын ГХЯ-ны сайд нарын хуралдаанаар Хятадын санаачлагаар НҮБ-ийн Ерөнхий

Ассамблейн чуулганы өмнө Байнгын төлөөлөгч нарын түвшинд зөвлөлдөх уулзалт хийж байхаар тохиролцож анхных нь 2001 оны 9 дүгээр сард Нью-Йоркт болсон байна.

Европын Комисс *Шинэ Азийн бодлогын үзэл баримтлалаа* боловсруулж гаргасны дараа АСЕАН-ны гишүүн улсууд болон БНХАУ, Япон, БНСУ-ЕХ-ны дээд уулзалт анх удаа 1996 онд Тайландын нийслэл Бангкок хотноо болсноор тив дамнасан интеграцийн хамтын ажиллагааны байнгын механизм АСЕМ буй болж АСЕМ-II 1998 онд Лондонд, АСЕМ-III 2000 онд Сөүлд, АСЕМ-IV 2002 онд Копенхаген хотноо хуралдлаа. АСЕМ-V 2004 онд Ханойд, АСЕМ-VI 2006 онд Хельсинк, АСЕМ-VII 2008 онд Бээжин, АСЕМ-VIII 2010 онд Брюссель, 2012 онд АСЕМ-IX Вьентян, АСЕМ-X Милан хотноо тус тус болов.

Европын Комисс 2001 онд *Европ-Ази: Өргөн хүрээтэй Түншлэлийн Стратегийн үндэс (Europe and Asia: A Strategic Framework for Enhanced Partnership)* хэмээх Шинэ Мянганд Европ-Азийн харилцаа, хамтын ажиллагааны түншлэлийн иж бүрэн, цогц бодлогыг шинээр боловсруулан гаргаж, түүнд хоёр тивийн хамтын ажиллагааны чиглэлийн талаар тодорхой томъёолсон бөгөөд түүнд Монгол Улсыг Сингапурын хамт нэг бүлэгт оруулсан байна.

Монгол Улс олон талт хамтын ажиллагааны хүрээнд ЕХ-той хамтран ажиллах ихээхэн ирээдүйтэй суваг болсон АСЕМ-д ажиглагч статусаас жинхэнэ гишүүнээр элсэн орсон явдал мөн бөгөөд АСЕМ нь Ази, Европын олон талт хамтын ажиллагаа, тив дамнасан интеграцчлалын бодит үйл явц мөн билээ. Энэхүү тив дамнасан интеграцийн олон талт эдийн засгийн дипломат ажиллагааны бүтцэд Монгол Улс 1998 оны Лондоны дээд хэмжээний уулзалтаас ажиглагчын статустай оролцох болсон юм.

Ази, Европын 22 орны төр засгийн тэргүүн, сайд нар 1996 оны 3 дугаар сард Бангкок хотноо уулзаж хоёр бүсийн хамтын ажиллагааны цаашдын хөгжил, дэвшлийн тусын тулд өргөн хүрээтэй түншлэн ажиллахаар тохиролцсон байна. Тус уулзалтаар эдийн засгийн өндөр чадамж бүхий гурван бүс болон Зүүн Ази, Өрнөд Европ, Хойд Америк дотроос Ази, Европын улс төр, эдийн засгийн харилцаа, харьцангуй сул хөгжиж ирснийг гол асуудал болгон хэлэлцжээ. Хоёр бүсийн улс

түмэн сайн ойлголцох явдал нь шинэ түншлэлийн чухал зорилго гэж тодорхойлсон байна. Тэгш эрхийн үндсэн дээр хоёр талын яриа хэлэлцээг өргөтгөх нь харилцан ойлголцох, үр ашигтай хамтран ажиллах явдлыг бэхжүүлнэ гэж үзжээ.

1995 оны байдлаар ЕХ-ны экспортын дөнгөж 9 хувь нь Азид [Зүүн болон Зүүн Өмнөд Ази, Австрали, Шинэ Зеландыг хэлсэн байна], Азийн экспортын 14 хувь нь ЕХ-нд ногддог байсан ажээ. Ази дахь гадаадын хөрөнгө оруулалтын дөнгөж 5 хувийг ЕХ эзэлж байв. Өнөөг хүртэл нэвтрэхэд хэцүү зах зээл хэмээн Азийхан Европыг үзэж байсан бол Европынхон Азийг төдий л ойшоолгүй явж иржээ.

Улс төрийн яриа хэлэлцээний талаар аюулгүй байдлын нийтлэг асуудал, ялангуяа итгэлцлийг бэхжүүлэх талаарх яриа хэлэлцээг өргөжүүлэхийн чухлыг уг уулзалтаар онцлон тэмдэглэсэн байна.

АСЕМ-ын анхдугаар чуулганы үеэр гаргасан мэдэгдэлд оролцогч талууд доорх салбарт хамтран ажиллахаар заажээ. Үүнд:

- *Дэлхийн Худалдааны Байгууллагын хүрээнд хамтран ажиллахаас эхлэн худалдааг хөнгөвчлөхөд тус дөхөм үзүүлэх;*
- *НҮБ-ын шинэчлэлийг ургашлуулах;*
- *Шинжлэх ухаан, технологийн солилцоог эрчимжүүлэх;*
- *Байгаль орчны асуудлыг шийдвэрлэхэд хамтын хүчин чармайлтыг нэгтгэх;*
- *Мансууруулах бодис, мөнгөний бохир угаалга, олон улсын зохион байгуулалттай гэмт хэрэг, терроризмийн эсрэг тэмцлийг хүчтэй болгох зэрэг асуудал багтаж байв.*

Дэлхийн цаг уурын дулааралт, усны нөөцийн хомсдол, ойгүйжилт, цөлжилт зэрэг дэлхий нийтийг хамарсан түгээмэл асуудлаар хамтран ажиллахын чухлыг АСЕМ-И уулзалтад оролцогчид хүлээн зөвшөөрсөн бөгөөд энэ чиглэлд тогтвортой хөгжлийг хангах үүднээс байгаль орчинд цэвэр техник, технологийг харилцан шилжүүлэх, судалгаа явуулах зэргээр хамтран ажиллахаар тохиролцжээ. Мөн мансууруулах бодисын хууль бус наймаа, олон улсын зохион байгуулалттай гэмт хэрэг, бохир мөнгө угаалт, олон улсын терроризмтэй хийх тэмцлийг эрчимжүүлэхэд хамтран ажиллахаар болжээ.

Цаашдаа гишүүдийн тоо хоёр тивийн аль алинаас нэмэгдэх боломжтой ба ойрын үед Австрали, Энэтхэг, Пакистан, Шинэ Зеландаар хүрээгээ тэлэх тухай ярилцсан байна. (2)

Ази, Европын дээд хэмжээний II чуулга уулзалт 1998 оны 4 дүгээр сард Лондон хотноо болж, уулзалтад Азийн 10, Европын 15 орны төр, засгийн тэргүүн, Европын Комиссын Ерөнхийлөгч тэргүүтэй төлөөлөгчид оролцов. Уулзалтыг ЕХ-ны Зөвлөлийн даргын хувьд Их Британийн Ерөнхий сайд Тони Блейр даргалсан юм.

Энэ удаагийн чуулга уулзалтаар хэлэлцэх асуудлыг урьдчилан товлгоогүй боловч цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан Азийн зарим оронд тохиолдсон санхүүгийн хямрал, түүнийг гэтлэн давах арга замын талаар тогтон ярилцжээ. Уулзалтад оролцогч Европын төлөөлөгчид Азийн зарим оронд учирсан санхүүгийн хямралыг богино хугацаанд арилгах нь Европын ч эрх ашигт нийцэхийг онцлон дурдаж хямралыг даван туулахад ОУВС, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк чухал үүрэгтэй болохыг тэмдэглэв. Уулзалтын үеэр Европ өөрийн зүгээс хямралыг давахад туслах зорилгоор санхүүгийн бүтцийн өөрчлөлт хийхэд зориулан Дэлхийн банкны зохицуулалтын дор 25 сая ам долларын тусгай сан байгуулж, хуримтлагдсан хөрөнгөөр Европын санхүүгийн know-how-г Азийн орнуудад нэвтрүүлэх, ЕХ-ны бизнесийн төлөөлөгчдийг тэдгээр оронд айлчлууулж, хөрөнгө оруулах шинэ боломжийг хайхад зарцуулахаар шийдвэрлэсэнээ зарлан мэдэгдэв. Хямралыг гэтлэн давахын тулд Азийн орнууд дотоод санхүүгийн системээ өөрчлөн, улам боловсронгуй болгох, ОУВС-тай ойр хамтран ажиллах, чуулга уулзалтын гишүүн орнуудын худалдааг хоёр урсгалтайгаар өргөжүүлэх, хөрөнгө оруулах шинэ боломжийг нээхэд түлхүү анхаарах шаардлагатай гэжээ.

Зүүн Азийг жинхэнэ ёсоор Азичлалын (asianisation) үндсэн дээр Азийн валютын санг (Asian Monetary Fund) байгуулах, Азийн нэгдсэн мөнгөн дэвсгэртийг буй болгох санал ч дэвшигдсэн байна.

Уулзалт АСЕМ-ын үйл ажиллагааны чиглэлийг мөн тодорхойлов. Үүнд:

- *Харилцан хүндэтгэл, ашигтай байдал, итгэлцлэлд тулгуурласан байх;*

- *Нээлттэй, хувьсан өөрчлөгдөж байх;*
- *Төрийн болон Засгийн газрын удирдлагуудын тохиролцоонд тулгуурласан байх;*
- *Харилцан ойлголцлыг төрүүлэх, дэмжих үйл ажиллагаанд тулгуурласан хамтын ажиллагаанд хүрэх;*
- *Гурван гол хүчин зүйлийг нэг эрчээр явуулах, улс төрийн харилцааг дэмжих, эдийн засгийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, бусад салбарт хамтын ажиллагааг өргөжүүлэх;*
- *АСЕМ нь бусад салбарт хөгжлийг хангах;*
- *Хоёр тивийн бизнесийн болон хувийн секторт хамтын ажиллагааг хөгжүүлэхийн тулд Засгийн газраас гадуур ажиллах зэрэг байлаа.*

АСЕМ нь хоёр тивийн судалгааны группийн хамтын үйл ажиллагааг дэмжих, үүнтэй уялдуулан удирдлагууд нь Гадаад хэрэг болон Эдийн засаг, Сангийн сайд нарын уулзалтанд болсон хэлэлцүүлгүүдийг дэмжсэн байна. (3)

2000 оны 10 дугаар сард болсон Сөүлийн АСЕМ-III дээд уулзалтын үеэр АСЕМ-II-оос хойшхи АСЕМ-ын үйл ажиллагаанд гарсан амжилтуудыг дурдаад Ази, Европын хамтын ажиллагааны хүрээг тодорхойлсон юм. Мөн 1999 онд болсон Гадаад хэргийн болон, Эдийн засаг, Сангийн сайд нарын хоёрдугаар уулзалтаар хэлэлцсэн асуудлуудыг дэмжин мөн онд болсон Шинжлэх ухаан, технологийн сайд нарын уулзалтыг амжилттай, үр дүнтэй болсон гэж дүгнэжээ. АСЕМ-III уулзалтад оролцогчид Ази, Европын хамтын ажиллагаа өргөжих өргөн төлөв бий болсныг талархан дэмжихийн зэрэгцээ Азид нүүрлээд байсан санхүүгийн хямралаас гарахад нааштай хандлага үүссэн, түүнд ЕХ-ны гишүүн орнуудын гүйцэтгэсэн үүрэг багагүй байсныг онцлон дурджээ. Энэ бол Ази, Европын хамтын ажиллагааны тус хоёр бүс нутгийн санхүүгийн салбарт олсон амжилт бөгөөд, хоёр бүс нутгийн хооронд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд ч ач холбогдолтой болов гэжээ. Тэд Азийн шинэчлэгдсэн эдийн засгийн эрч хүч, Европын өсч буй эдийн засгийн эрч хүч нь хоёр тивийн тогтвортой байдал, хөгжил дэвшилд дэм болно гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийлсэн байна.

АСЕМ-III дээд хэмжээний уулзалтаас гаргасан “Солонгосын хойгын энх тайвны төлөөх Сөүлийн Тунхаглал”-д тэмдэглэхдээ: Хоёр Солонгосын 2000 оны 6 дугаар сарын дээд уулзалтыг сайшаагаад энэ нь түүхэн алхам болсон гэж үзжээ. (4)

2002 оны 9 дүгээр сард Данийн нийслэл Копенхагенд болсон АСЕМ-IV чуулга уулзалт нь 2001 оны 9 дүгээр сарын 11-ний олон улсын террорист ажиллагааны дараа болсон анхны уулзалт байснаараа онцлог байв. «Олон улсын терроризмийн эсрэг АСЕМ-ын Копенхагены тунхаглал»-д Олон улсын терроризм нь олон улсын энхтайван, аюулгүй байдалд маш хор хөнөөлтэй бөгөөд бүх хүн төрөлхтөн, улс орны иргэдийг энэ бүхэнтэй тэмцэхийг уриалж байна. Терроризм нь ямар ч гэмгүй хүмүүсийн амь насанд халдахаар барахгүй, бид бүхний бүтээн байгуулсан нийгмийг тэр чигээр нь хөнөөх ч аюултай юм. Бид бүх террорист үйл ажиллагааны эсрэг зогсох бөгөөд, үүнд ЕХ болон АСЕАН-ны бүс нутгуудийн дэмжлэгийг улам ихээр авах болно. Бид бүхэн улс гүрнүүдийн эдийн засгийн хөгжилд, улс төрийн тогтвортой байдлын төлөө хүчээ дайчлах бөгөөд, терроризмтэй тэмцэхэд НҮБ-ын дүрэм нь олон улсын эрхзүйн үндсэн суурь болж өгөх ёстой гэж үзэж байна. Терроризмийн эсрэг олон улсын хүчин чармайлтыг үргэлжлүүлэх, үүнд НҮБ-ын үүрэг оролцоог онцлон тэмдэглэв. Үүнтэй уялдуулан НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлөөс гаргасан шийдвэрийг дэмжихээ илэрхийлжээ.

Солонгосын хойгийн талаар гаргасан Копенхагены тунхаглалд, Солонгосын хойгийн эрчим хүчний хөгжлийн байгууллагын (KEDO)³ үйл ажиллагааг идэвхжүүлэх, эл байгууллагыг маш чухал гэж үзсэн байна.

3. КЕДО (Korean Peninsula Energy Development Organisation-KEDO) нь Хойд Солонгосын Ёнбён дахь Цөмийн судалгааны төв дэх цөмийн зэвсгийн хөтөлбөрийг зогсоох, Кумхо дахь технологийн хувьд хоцрогдсон бал чулууны цөмийн реакторыг хөнгөн усны реактороор 2003 он гэхэд сольж дуусгах зорилгоор 1994 онд АНУ-Хойд Солонгосын хооронд байгуулсан гэрээг хэрэгжүүлэх зорилгоор 1995 оны 3 дугаар сард Нью Йоркт АНУ, Япон, Өмнөд Солонгос гурван улсын байгуулсан Солонгосын хойгийн эрчим хүчний хөгжлийн байгууллага юм. КЕДО-д 1995 онд Австрали, Шинэ Зеланд, Канад, 1996 онд Аргентин, Чили, Индонез, 1997 онд ЕХ (Euratom), Польш, 1999 онд Чех, 2000 онд Узбекистан гишүүнээр элсчээ. 1995-2005 оны хооронд 10 жилийн хугацаанд КЕДО-гийн санд Өмнөд Солонгос 1 тэрбум 455 сая, Япон 498 сая, АНУ 405 сая, ЕХ 122 сая, Австрали 14 сая, бусад улс 18 сая ам. долларын санхүүжилт хийжээ. Гэвч Хойд Солонгосын гэжүүд бодлогын улмаас 2006 оны 1 дүгээр сард энэ байгууллагын үйл ажиллагаа бүрэн зогсч, барилгын мэргэжилтэн ажилчид нь нутаг буцсан байна.

Эдийн засгийн чиглэлд Ази, Европ хоёр тивийн эдийн засгийн түншлэлийг ойртуулах талаар ярилцаж, бүс нутгийн орнуудаас худалдаа, хөрөнгө оруулалт, жижиг, дунд үйлдвэрлэл, мэдээлэл, холбооны технологи, банк, санхүүгийн салбаруудад мэргэжлийн бүрэлдэхүүнтэй группийг байгуулж эдийн засгийн судалгаа хийлгэхээр болжээ. (5)

АСЕМ-V 2004 оны 10 дугаар сард Вьетнамын нийслэл Ханой хотноо амжилттай болж өндөрлөжээ. Уулзалтад Азийн 13, Европын 25 улс орны төр, засгийн дээд удирдлагууд, Люксембургийн Ерөнхий сайд бөгөөд ЕХ-ны Зөвлөлийн Ерөнхийлөгч, Вьетнамын Ерөнхий сайд нар оролцов. Чуулга уулзалт даяаршлын үеийн олон улсын аюулгүй байдлыг хэлэлцсэнээс гадна эдийн засгийн түншлэл дээр Азийн эдийн засгийн өсөлт, ЕХ-ны эдийн засгийн харьцаа сайжирсаныг сайшаан дэмжиж, АСЕМ-ын түнш орнуудын дотоодын эдийн засгийн өөрчлөлт, шинэчлэлтийг ямагт дэмжиж байхаа илэрхийлэв. Ази, Европын эдийн засгийн түншлэл нь улам хөгжиж дэвшихийн төлөө «АСЕМ-ын эдийн засгийн түншлэлийн Ханойн тунхаглал»-ыг гаргахад хүргэсэн бөгөөд, энэ нь маш чухал зүйл болсон гэж үзсэн юм.

Уулзалтаар, нефть үйлдвэрлэгчдийг үнээ хэт хөөрөгдүүлэхгүй байхыг, бас бүс нутаг тус тусын өөрсдийн хэрэглээ, зарцуулалтанд хяналт тавихыг анхааруулсан байна.

АСЕМ-ын удирдагчид эдийн засгийн интеграци нь ямарваа улс үндэстэн, шашин шүтлэгийн ялгаагүйгээр явагдаж байгааг тэмдэглээд эдгээр нь ДХБ-ын үндсэн хууль, тогтоомж дээр тулгуурлан явагдах болно гэжээ.

АСЕМ-ын өргөжилт нь энэ удаагийн уулзалтын хамгийн онцгой үйл явдал гэж үзсэн байна. Азийн гурван орон [Камбож, Лаос, Мьянмар], Европын 10 [Чех, Унгар, Польш, Эстони, Латви, Литва, Словак, Словени, Мальт, Кипр] орны төр, засгийн тэргүүд анх удаа оролцсон бөгөөд АСЕМ-д нэгдэн орох асуудлыг албан ёсоор хүлээн зөвшөөрч халуунаар хүлээн авсан юм. Эдгээр шинэ оролцогч 13 орон нь АСЕМ-ын үйл ажиллагаанд шинэ эрч хүч нэмж байгааг илэрхийлсэн байна. (6)

АСЕМ-VI дээд хэмжээний уулзалт төр, засгийн тэргүүдийн түвшинд 2006 оны 9 дүгээр сард Финландын нийслэл Хельсинк хотноо болов. Энэ удаагийн уулзалтын онцлог нь АСЕМ-ын хамтын ажиллагааны чуулганы 10 жилийн ой, АСЕМ-ын шинэ өргөжилт болсон явдал юм. Дээд чуулганы өмнө 2006 оны 3 дугаар сард АСЕМ-ын ахлах мэргэжилтнүүдийн уулзалт Австрийн Вена хотод, Гадаад хэргийн сайд нарын уулзалт Японы Киото хотод 2005 онд болжээ.

АСЕМ-VI уламжлалт худалдаа, өрөнгө оруулалт, аюулгүй байдлын асуудлыг хэлэлцсэний гадна чуулган «Уур амьсгалын өөрчлөлтийн Хельсинкийн тунхаглал»-ыг батлан гаргав. «Цаг уурын өөрчлөлт дэлхийн тогтвортой хөгжилд асар том харангын дохио өгч байна хэмээн АСЕМ-ын гишүүн орнуудын удирдлага үзэж байна» гэж ЕХ-ны Зөвлөлийн Ерөнхийлөгч, Финляндын Ерөнхий сайд Матти Ванханен тэмдэглэв.

Түүнчлэн дээд уулзалтаар «АСЕМ-ын ирээдүйн өөд Хельсинкийн тунхаглал» гаргаж, 2006-08 оны АСЕМ-ын үйл ажиллагааны хуанлийг баталсан байна.

Чуулганы чухал үйл явдал нь нээлтийн ёслол дээр Финландын Ерөнхий сайд Матти Ванханен Ази, Европын хооронд харилцан хэлэлцсэний дүнд *Монгол*, Пакистан, Энэтхэг улсуудыг АСЕМ-д шинэ гишүүнээр элсүүлснийг зарлан мэдэгдсэн явдал юм. «Манай түншлэлийн өргөжилт хамгийн чухал шийдвэр байсанд би туйлын баяртай байна» гэж тэрбээр хэлжээ. (7)

ЕХ АСЕМ-VI уулзалтын өмнө Болгар, Румын улсуудыг өөрийн шинэ гишүүнээр элсүүлэх шийдвэр гаргасан байсан юм.

АСЕМ-VI дээд уулзалтад 1500 гаруй төлөөлөгчид оролцож, Хельсинкийн дээд хэмжээний уулзалтаар АСЕМ-ын цахим (cyber secretariat) нарийн бичгийн дарга нарын газар байгуулахаар шийдвэрлэж, ээлжит АСЕМ-VII дээд чуулганыг 2008 оны 10 дугаар сард Хятадын нийслэл Бээжинд, зуны олимпийн жил зохиохоор шийдвэрлэсэн байна.

Монгол Улс АСЕМ-д гишүүнээр элссэнээр дараах ажлын хэсгүүдэд оролцож, үр ашгийг нь хүртэх боломжтой болж байна. Үүнд:

1. Ази-Европын хамтын ажиллагааны Зөвлөл (Council of Asia-Europe Co-operation)-ийг дурдаж болно. САЕС бол хоёр бүс нутаг тус бүрээс 6 хүний бүрэлдэхүүнтэй шинжээчдийн баг бүхий бодлогын сүлжээний групп юм.
2. 1996 оны 6 дугаар сард Хятадын Шензен хотод байгуулагдсан АСЕМ-ын Гаалийн хамтын ажиллагааны Ажлын хэсэг (Working Group on Customs Co-operation),
3. Хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагааны хөтөлбөр (Investment Promotion Action Plan - IPAP),
4. Худалдааг хөнгөвчлөх үйл ажиллагааны хөтөлбөр (Trade Facilitation Action Plan - TFAP),
5. Худалдаа, хөрөнгө оруулалтын талаарх ахлах мэргэжилтнүүдийн уулзалт (Senior Officials Meeting on Trade and Investment - SOMTI) нь ажлын гурван хэсэгтэй бөгөөд 1996 оны 12 дугаар сард Сингапурт болсон ДХБ-ын сайд нарын уулзалтаар буй болсон.
6. Ази-Европын бизнесийн чуулга (Asia-Europe Business Forum - AEBF) нь ажлын таван хэсэгтэй, Парист байгуулагдсан. Үүнд: жижиг, дунд үйлдвэрлэл, дэд бүтэц, аялал жуулчлал, аж үйлдвэрийн бүтээгдэхүүн, өргөн хэрэглээний бүтээгдэхүүн, санхүүгийн үйлчилгээ зэрэг болно. АСЕМ-II уулзалтаар эрчим хүч, харилцаа холбоо, мэдээллийн технологи, төмөр замын Евроазийн сүлжээ, ус гэсэн ажлын хэсэг байгуулагдсан юм.
7. Ахлах мэргэжилтнүүдийн уулзалт нь АСЕМ-ын үйл явцыг зохицуулагч болно.
8. Гадаад хэргийн сайд нарын уулзалт нь 1997 оны 2 дугаар сард Сингапурт анх болсон улс төрийн яриа хэлэлцээний механизм юм.
9. Эдийн засгийн сайд нарын уулзалт нь IPAP, TFAP-г оролцуулан макро эдийн засгийн өөрчлөлтийн асуудал хэлэлцдэг.
10. Санхүүгийн сайд нарын уулзалт нь хоёр бүсийн макро эдийн засгийн нөхцөл, евро болон валютын зах зээлийн асуудал хэлэлцдэг. Анхны уулзалт 1997 оны 9 дүгээр сард Тайландын нийслэл Бангкок хотноо болсон байна.

11. АСЕМ-ын алсын хараа бүлэг (ASEM Vision Group) нь Ази, Европын хамтын ажиллагааны дунд болон урт хугацааны хэтийн төлөвийн боловсруулдаг эрдэмтдийн бүлэг Think tank бөгөөд нийт 26 гишүүнтэй 10 нь Азийн улс, 15 нь ЕХ-ных, үлдсэн нэг нь Европын Комиссын гишүүн байдаг. (8)

АСЕМ-ын Алсын хараа групп бодлогын зөвлөмжийг бэлтгэн гаргадаг, тухайлбал 1999 оны 3 дугаар сард «Илүү дээр ирээдүйн төлөө: XXI зуун дахь Ази-Европын түншлэл» нэртэй бодлогын зөвлөмжийн баримт бичгийг АСЕМ-ын гишүүн улсуудын Гадаад хэргийн сайд нарын уулзалтанд зориулж боловсруулжээ. Энэ баримт бичгийг 2000 онд Сөүлд болсон АСЕМ-III дээд чуулганд танилцуусан бөгөөд утгын хувьд Ази-Европын хоорондох материаллаг сонирхол, үзэл бодлын талаар өгүүлсэн байна.

Улс төр-аюулгүй байдлын асуудлын хувьд хүрээлэн буй орчны асуудлыг хөндсөн байна. Сайхь асуудлын хүрээнд «АСЕМ-ын хүрээлэн буй орчны технологийн төв»-ийг байгуулахаар тогтсон байна. Мөн иргэдийг улс төр, соёл, эдийн засгийн эрхээр бүрэн хангах явдал бол сайн засаглалын үндсэн зарчим хэмээн тодорхойлжээ.

Технологийн асуудлын хүрээнд «АСЕМ-ын Мэдээллийн технологийн Зөвлөл»-ийг технологийн стандартчлал, мэдээлэл доод түвшинээс шалтгаалж үүсэх технологийн саадыг арилгах асуудалд анхаарлаа хандуулахыг зөвлөжээ. (9)

12. Ази-Европын Хүрээлэн Буй Орчны Технологийн Төв (Asia-Europe Environmental Technology Center) нь байгаль орчинд хоргүй технологи нэвтрүүлэх R&D-г хэрэгжүүлдэг эдгээр болно. (10)

Монгол Улс 2006 онд элсэн орсон АСЕМ-ын үйл ажиллагааны арга хэмжээнүүдэд оролцох ажлыг зохион байгуулж ирсэн юм. Үүнд: ХБНГУ-д болсон АСЕМ-ын Гадаад хэргийн сайд нарын уулзалт, Ахлах албан тушаалтнуудын уулзалтад оролцов. Мөн Нидерландад болсон Ази-Европын Залуу парламентчдын 6 дугаар чуулга уулзалт, Данид болсон АСЕМ-ын Байгаль орчны сайд нарын уулзалт, Токиод болсон Терроризмтой тэмцэх асуудлаарх бага хурал, Шведэд болсон ДОХ-той

тэмцэх асуудлаарх семинар, БНХАУ-д болсон Шашин хоорондын яриа хэлэлцээний 3 дугаар уулзалтуудад төлөөлөгчид оролцсон нь ЕХ болон АСЕАН-ы орнуудтай ойртон нягтрах, бие биеэ илүү таньж мэдэхэд ач холбогдолтой болов.

2008 оны 10 дугаар сард БНХАУ-ын нийслэл Бээжин хотноо Ази-Европын Дээд хэмжээний АСЕМ-ҮП уулзалт болов. Дээд уулзалтад АСЕМ-ын гишүүд болох ЕХ-ны 27, АСЕАН-ы 10, Европын Комисс, АСЕАН-ы нарийн бичгийн дарга нарын газар, БНХАУ, БНСУ, Япон, Монгол, Пакистан, Энэтхэг гэсэн нийт 43 гишүүн улсын Төрийн тэргүүд, Ерөнхий сайд нар оролцжээ. Шинэ өргөжилтөөр АСЕМ нь 45 түншлэгчийг багтааж, түүнд дэлхийн худалдааны 60 хувь нь ногдож байна. Дээд хэмжээний 7 дахь уулзалтын үеэр дараах үндсэн асуудлуудыг хэлэлцжээ. Үүнд:

1. *Дэлхийн эдийн засаг, санхүүгийн байдал,*
2. *Глобаль буюу дэлхий дахиныг хамарсан асуудлууд (Санхүүгийн хямрал, хүнсний аюулгүй байдал, байгаль, цаг уурын гамшигийг сөрөх чадварыг нэмэгдүүлэх),*
3. *Тогтвортой хөгжлийг хангах нь (Мянганы хөгжлийн зорилт, эрчим хүчний аюулгүй байдал, уур амьсгалын өөрчлөлт, нийгмийн эв нэгдлийг хөгжүүлэх),*
4. *Соёл иргэнийн хоорондын яриа хэлэлцээг гүнзгийрүүлэх нь гэсэн үндсэн сэдвүүд байв.*

Монгол Улсын Ерөнхийлөгч Н. Энхбаяр АСЕМ-ын дээд уулзалтад оролцож, “Тогтвортой хөгжлийг хангах нь” сэдвээр үг хэлсэн байна. Энэ нь Монгол Улс 2006 онд тус байгууллагын гишүүн болсноос хойш анх удаа дээд уулзалтад оролцсон чухал үйл явдал болов.

Дээд хэмжээний уулзалтын дүнгээр “АСЕМ-ын 7 дахь дээд уулзалтыг даргалагч орны мэдэгдэл”, “Тогтвортой хөгжлийн асуудлаарх Бээжингийн Тунхаглал” гэсэн хоёр үндсэн бичиг баримтыг гаргажээ.

Уулзалтын үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр БНЭУ-ын Ерөнхий сайд М.Сингх, Японы Ерөнхий сайд Т.Асо, Нидерландийн Вант улсын Ерөнхий сайд Я.П.Белканенде, Эстоний

Ерөнхий сайд А.Ансип нартай, Гадаад харилцааны сайд С.Батболд БНХАУ-ын Гадаад хэргийн сайд Ян Жэчи, БНФУ-ын Гадаад хэргийн сайд Б.Күшнер, Словакын Гадаад хэргийн сайд Я.Кубиш нартай тус тус хоёр талын уулзалт хийж, олон улс, бүс нутаг, хоёр талын харилцааны асуудлаар санал солилцов. Мөн үеэр Хятадын банк, санхүүгийн томоохон байгууллагуудын удирдлагуудтай ажил хэргийн уулзалт хийж, Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчин, эдийн засгийн байдал, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, хамтран ажиллах бололцоо, нөхцөл зэрэг өргөн хүрээтэй асуудлыг хөндөж ярилцсан байна.

АСЕМ-VIII ээлжилт дээд уулзалт 2010 оны 10 дугаар сард ЕХ-ны төв байрладаг Бельгийн Вант улсын нийслэл Брюссель хотноо болов. Энэ удаагийн уулзалт “Амьдралын чанар, Аугаа их хүн төрөлхний илүү цог жавхааг буй болох нь” нэрийн дор болж өнгөрөв. Төр, засгийн тэргүүн нар Ази-Европын хооронд стратегийн яриа хэлэлцээ, хамтын ажиллагаа гүнзгийрч, тэгш түншлэл амжилттай хөгжиж байгааг цохон тэмдэглэсэн байна. Илүү үр ашигтай глобал эдийн засгийн засаглал шаардлагатай байгааг тэмдэглээд тогтвортой хөгжлийг хангах, эдийн засгийн өсөлтийг зөв жолоодох, ажлын байрыг нэмэгдүүлэх, Дохагийн үе шатны хэлэлцээрийг дуусгах, тарифыг тууштай бууруулах, тарифын бус саадыг арилгах, цэвэр технологийг өргөн нэвтрүүлэх, цаг уурын өөрчлөлтөд дасан зохицох зэрэг олон асуудлыг хэлэлцсэн байна.

Энэ уулзалтын онцлог нь ОХУ, Австрали, Шинэ Зеландыг АСЕМ-д гишүүнээр элсүүлсэн явдал байв. АСЕМ-VIII уулзалтад Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж тэргүүтэй төлөөлөгчид оролцож, уулзалтын үеэр «Эдийн засаг, санхүүгийн засаглал», «Тогтвортой хөгжил», «Глобал асуудлууд», «Бүс нутгийн асуудлууд», «Иргэд хоорондын харилцаа, АСЕМ-ын үүрэг роль, түүний ирээдүй» зэрэг сэдэвчилсэн хэлэлцүүлэгт оролцож Монгол Улс байр сууриа илэрхийлсэн нь АСЕМ-ийн хүрээнд бусад түншүүдтэй хамтран ажиллах чиглэлээ тодорхойлсон чухал алхам болов.

2012 оны 11 дүгээр сард БНАЛАУ-ын нийслэл Вьентян хотноо АСЕМ-IX дээд уулзалт болж, амжилттай өндөрлөв. Энэ арга хэмжээнд Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж оролцсон юм. Дээд түвшний уулзалтын үеэр гишүүн улсууд бүс нутаг, олон улсын

хамтын ажиллагааны өргөн хүрээтэй асуудлыг хөндөж, “Эдийн засаг, санхүүгийн асуудлууд”, “Дэлхий дахиныг хамарсан асуудлууд”, “Нийгэм, соёлын хамтын ажиллагаа”, “Бүс нутгийн асуудлууд”, “АСЕМ-ын цаашдын хөгжлийн чиг хандлага” зэрэг сэдэвчилсэн хэлэлцүүлэг өрнүүлсэн юм. Уулзалтад 30 гаруй улсын төр, засгийн тэргүүн, АСЕАН-ы Ерөнхий нарийн бичгийн дарга, ЕХ-ны зөвлөлийн дарга, Европын комиссын Ерөнхийлөгч нар оролцов. 2010 онд тус байгууллагад гишүүнээр элссэн ОХУ, Австрали, Шинэ Зеланд улс анх удаа АСЕМ-ын дээд уулзалтад оролцож байгаагаараа онцлог болов. Мөн уулзалтаар Азиас Бангладеш, Европоос ЕХ-ны гишүүн бус Норвеги, Швейцари гишүүчлэлтэй болов.

2014 оны ээлжилт АСЕМ-Х дээд уулзалт Италийн Милан хотноо зохион байгуулагдав. Энэ удаагийн дээд уулзалт “Өсөлт, Аюулгүй байдлын хариуцлагатай Түншлэл” уриан дор болж амжилттай өндөрлөв. Уулзалт АСЕМ-ын улс төр, эдийн засаг, нийгэм, соёл боловсрол гэсэн гурван тулгуурт үзэл баримтлалдаа тулгуурлан нэгд, хариуцлага: энэ хүрээнд хүрээлэн буй орчныг хамгаалах, нийгмийн яриа хэлэлцээ, хүний эрхийг хамгаалан дэмжих, хоёрт, түншлэл: глобал болон бүс нутгийн хамтарсан түншлэлд суурилсан өргөжилтийн чиг хандлагийг гүнзгийрүүлэх, гуравт, тогтвортой өсөлт: Ази, Европын эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг гүнзгийрүүлэх үндсэн дээр худалдаа, хөрөнгө оруулалтыг өргөжүүлэх, дөрөвт, аюулгүй байдал: өргөжилт нь аюулгүй байдалгүйгээр хөгжихгүй. Иймд далайн аюулгүй байдал, уламжлалт бус аюулгүй байдал, нийгмийн аюулгүй байдал, хүнсний аюулгүй байдал, цөмийн аюулгүй байдлыг хангах, энэ хэрэг ЕХ чухал үүрэг гүйцэтгэж байгааг авч үзэж хамарсан мэдэгдэл гаргав. Дээд уулзалт Казахстан, Хорват улсыг АСЕМ-д элсүүлснийг мэдэгдэж, 2015 оны 4 дүгээр сард Нидерландын Хаага хотноо Кибер орон зайн глобал бага хурал хуралдуулах болсныг тэмдэглэж, Ази-Европын санхүүгийн хамтын ажиллагааны зохицуулалт, Европын Тогтворуулалтын механизм, Чиань Майн санаачилгын олон талт механизмд анхаарлаа хандуулав.

2016 онд АСЕМ-ын 20 жилийн ой тохиож байгаа бөгөөд энэхүү ээлжит дээд уулзалтыг Улаанбаатар хотод хийхээр шийдвэрлэсэн нь Монгол Улсын хувьд нэр төрийн хэрэг, олон улсын тавцанд тус улсын байр бэхжиж байгаагийн тодорхой илрэл болов.

Дэлхийн цаг уурын дулаарал зэрэг глобал асуудлууд АСЕМ-ын анхаарлын төвд байгаа нь ойлгомжтой. Уур амьсгалын өөрчлөлт, түүнд дасан зохицох, сөрөг үр нөлөөг бууруулах, байгаль орчны тогтвортой байдлын асуудлаар НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх гол конвенциудын хэрэгжилтийг хангах, Дэлхийн эдийн засгийн чуулга уулзалтын хүрээнд зэрэг олон улсын түвшинд дурдсан асуудлаар идэвхтэй яриа хэлэлцүүлэг өрнөж, үүнд Монгол Улс оролцсоор ирэв.

“Тогтвортой өсөлтийн төлөөх хариуцлагатай түншлэл” сэдвээр 2014 оны 10 дугаар сард Италийн Милан хотноо АСЕМ-Х дээд уулзалт зохион байгуулагдах бөгөөд 2016 онд АСЕМ-ын 20 жилийн ойг тэмдэглэнэ.

2012 оны 5 дугаар сард «Ус ба ойн асуудлаарх АСЕМ-ын Байгаль орчны сайд нарын түвшний ээлжит уулзалт»-ыг Монгол Улс өөрийн орон анх удаа зохион байгуулав. Мөн Улаанбаатар хотод анх удаа зохиогдсон АСЕМ-ын олон талт арга хэмжээ болов. АСЕМ-ын гишүүн орнуудын Байгаль орчны сайд нарын түвшний уулзалтуудыг өмнө нь Хятад 2002 онд, Итали 2003 онд, Дани 2007 онд тус тус зохион байгуулж байсан ажээ.

Байгаль, цаг уурын эрс тэс уур амьсгалтай Монгол Улсын хувьд уур амьсгалын өөрчлөлтийн таагүй сөрөг нөлөөллийг бууруулах, тулгарч байгаа сорилтуудыг даван туулах, эко орчны тэнцвэртэй байдлыг хадгалахад чиглэсэн бүс нутгийн орнуудын хамтын ажиллагааг эрчимжүүлэх үүднээс идэвх санаачлага гарган ажиллаж, 2007 онд Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх ЗХА-ийн орнуудын дээд уулзалтыг зохион байгуулах санаачлага дэвшүүлж, улмаар 2009 онд бүс нутгийн орнуудын Байгаль орчны асуудал эрхэлсэн газрын дарга нарын болон сайд нарын түвшний уулзалтыг Улаанбаатар хотноо тус тус зохион байгуулсан байна.

АСЕМ-ын гишүүн орнуудын Байгаль орчны сайд нарын түвшний уулзалтыг өөрийн улсад зохион байгуулах нь дэлхийн нийтийн тулгамдсан асуудал болох Ус ба ойн тогтвортой менежментын асуудлаар Монгол Улсын Засгийн газраас баримталж буй бодлого, байр суурийг таниулах, ЗХА-ийн дээд уулзалтыг зохион байгуулах санаачлагаа урагшлуулах, бүс нутгийн болон олон улсын хэмжээнд хамтын ажиллагаагаа өргөжүүлэхэд ихээхэн ач холбогдолтой болов.

АСЕМ-ын уулзалт тогтмолжиж, түүний бүтэц зохион байгуулалт, төлөвшил, түүнд оролцох сонирхолтой орнуудын тоо нэмэгдэж байгаа нь даяаршлын үеийн эдийн засгийн интеграцийн чухал хандлага болж байна. Хэдийгээр АСЕМ нь эдийн засгийн интеграцийн бодит бүтцийг бий болгож хараахан амжаагүй ч хэл, соёл, эдийн засгийн хөгжлийн түвшин, газарзүйн байрлал, үндэстэн ястан, шашин шүтлэгийн хувьд эрс ялгагдах хоёр өөр бүс нутгийн хооронд эдийн засгийн интеграцийг хөгжүүлэх, худалдаа хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, түүнчлэн дэлхий нийтийн өмнө тулгараад буй түгээмэл бэрхшээлтэй асуудлыг даван туулахад санаа зорилгоо нэгтгэн хамтарсан тунхаглал гаргаж, түүнийгээ мөрдөж байгаа нь улам бүр даяаршиж байгаа дэлхийн эдийн засгийн үйл ажиллагааг эрчимжүүлэхэд чухал алхам болж байна. Тухайлбал Ханой-V уулзалтын үеэр гаргасан тунхаглалыг үзвэл эдийн засгийн хамтын ажиллагаагаар тогтохгүй ДОХ, Олон улсын терроризм, Хельсинк-VI уулзалтаар цаг уурын өөрчлөлт, Бээжин-ҮII уулзалтаар дэлхийн эдийн засаг, санхүүгийн хямрал, Бельги-ҮIII уулзалтаар амьдралын чанарыг сайжруулах зэрэг чухал асуудлыг хамтын хүчин чармайлтаар шийдвэрлэх дээр санал нэгдэж байгаа нь Ази-Европын хоёр бүс нутгийн энэхүү үйл ажиллагаа нь хүн төрөлхтний хөгжлийн төлөө аль ч тив, улс орны хүн зон нэгэн сэтгэлтэй байгааг харуулж байгаа юм. Ийнхүү орчин үеийн олон улсын эдийн засгийн харилцааны онцлох үйл явц болсон бүс нутгийн интеграцийн үйл явц зөвхөн бүс нутгаар хязгаарлагдахгүй дэлхийн эдийн засгийн томоохон хоёр төв болох Ази-Европыг холбож, улмаар тив хооронд худалдаа, хөрөнгө оруулалт, ажиллах хүч, технологи чөлөөтэй шилжих нөхцлийг бүрдүүлэхийн төлөө ажиллаж байгаа бодит үйл явц болж байна.

Улс төр, худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан-технологи, экологи, соёл, хүмүүнлэгийн өргөн хүрээтэй асуудлыг өндөр түвшинд хэлэлцдэг Ази-Европын олон талт хамтын ажиллагааны хэлбэр АСЕМ-ийн бүрэн эрхт гишүүн болсны хувьд Монгол Улсын Засгийн газар цаашид энэ чиглэлд хамтран ажиллах тусгайлсан бодлогоо боловсруулж гаргах шаардлагатай.

ЭШЛЭЛ ЗҮҮҮЛТ

1. Dent, Christopher M, The European Union and East Asia: An Economic Relationship. 2d ed. L, N.Y.: 2005, pp. 240-241
2. Ibid. p. 242
3. Ibid. p. 244
4. Ibid. p. 247

<http://www.gov.vi/2004/asem5/>

<http://www.gov.fi/2006/asem6/>

Dent ... p. 243

Ibid

Ibid

Ibid